



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/27

Номгон

Ажиллах цагийн хуваарийг энгийн горимд шилжүүлж, эм зүйн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх, 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хоёрдугаар хурлын шийдвэрийн дагуу "Монос Баянхонгор" ХХК-ийн (РД:3136574) эзэмшиж буй Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах (Нэгдүгээр зэрэглэл) ЭСХ-20/03/001 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн хүрээнд ажиллах цагийн хуваарийг энгийн цагийн горим (09:00-22:00 цаг)-д 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс шилжүүлсүгэй:

2. Энгийн цагийн горимд шилжсэнтэй холбогдуулан "Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS5260:2015 стандарт, Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандарт, эм зүйн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг "Монос Баянхонгор" ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, эм зүйн тусламж үйлчилгээний бэлэн байдлын уялдаа холбоог зохицуулж ажиллахыг Эмнэлгийн тусламж хэлтсийн Эм, эмнэлгийн хэрэгсэл вакцин биобэлдмэлийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (С.Дуламсүрэн)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЛХАГВА-ОЧИР



642001079